



“СТАНДАРТ НООС” ХК-ИИ ЏАНХҮҮГИЙН  
БОЛОН ХАРААТ БУС АУДИТОРЫН  
ТАЙЛАН



СТАНДАРТ НООС ХК-ний САНХҮҮГИЙН ТАЙЛАН 2024 ОНЫ 12 САРЫН 31

АГУУЛГА	ХУУДАС
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН мэдэгдэл	
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН	
САНХҮҮГИЙН ТАЙЛАН	
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	1
ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН	2
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	3
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	4
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	5



## АЯА ТАКС АУДИТ ХХК

Улаанбаатар хот, СБД, I хороо, V  
хороолол, 14251, Чингисийн өргөн  
чөлөө 19-Б Бизнес тауэр 11 давхар  
Утас: 99994447, 98658500

03 > (^ № &Г/  
Танай-ны № /// "т"

## СТАНДАРТ НООС ХК-ИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН БОЛОН  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

### *Хязгаарлалтгүй дүгнэлт*

Бид СТАНДАРТ НООС ХК-ий 2024 оны 12 сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн иж бүрэн орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бид 2024 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх)-ын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

### *Дүгнэлтийн үндэслэл*

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид "НБЁЗОУСЗ-ын дүрэм" гэх)-ийн дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

### *Аудитын гол асуудлууд*

Бидний мэргэжлийн үнэлэмжээр Аудитын гол асуудлууд нь тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг тайлант оны байдлаар авч үзэж дүгнэлт гаргасан болно.

#### *а/ Бараа материалын үнэлгээ*

Удирдлага удаан гүйлгээтэй болон хуучирсан бараа материалын хасагдуулгыг тодорхойлохдоо үлэмж хэмжээний төсөөлөл болон үнэлэмж ашигладаг учраас бид

бараа материалын үнэлгээг аудитын гол асуудал гэж үзсэн. Нягтлан бодох бүртгэлийн бодлогоор бараа материалын үнэлгээг тооцохдоо бараа материалын насжилт дээр үндэслэн өмнөх жилүүдийн туршлага, түүхэн мэдээлэлд үндэслэн тооцсон алдагдлын хувийг ашиглан тооцдог.

Бараа материалын үнэлгээтэй холбоотой бидний гүйцэтгэсэн горимууд:

- 4- Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийг тооцохдоо ашигласан удирдлагын үнэлгээ болон бараа материалыг тэдгээрийн цэвэр боломжит үнэ цэнэ хүртэл залруулж, бараа материалын сан байгуулах дотоод горимыг судлах, ойлгох;
- 4- Борлуулалтын түүхэн мэдээ, өнөөгийн зах зээлийн орчин, маркетинг болон урамшууллын төлөвлөгөө, бараа материалын насжилт болон бараа материалын борлуулалтын үнэ зэрэгт үндэслэн бараа материалын хасагдуулга нь зохистой эсэхийг үнэлэх;
4. Түүврийн аргаар бараа материалын насжилтыг холбогдох анхан шатны баримттай нь тулгаж шалгах;
- 4- Түүврийн аргаар бараа материалын борлуулалтын үнийг холбогдох анхан шатны баримттай тулгаж шалгах.

Дансны ба бусад авлагын эргэн төлөгдөх байдлыг үнэлэхтэй холбоотой бидний гүйцэтгэсэн горимууд:

б/ Дансны ба бусад авлагын эргэн төлөгдөх байдал

- 4- Удирдлагын авлагыг тооцоолдог горимыг судлах, ойлгох;
4. Төлөгдөөгүй авлагын үлдэгдэлд байж болох боломжит эрсдлийн хэмжээг тооцоолох болон ойлгох зорилгоор түүврийн аргаар дансны ба бусад авлагын насжилтыг холбогдох анхан шатны баримтуудтай нь тулгаж шалгах;
4. Төлөгдөх хугацаа нь 60 хоногоос хэтэрсэн авлагууд нь даатгагдсан эсэхийг үнэлэхийн тулд даатгалын гэрээтэй нь тулгах, тайлант хугацааны дараа цуглуулагдсан дүнгүүдийг шалгах. Даатгагдаагүй авлагуудын хувьд, тухайн харилцагчдийн өмнөх жилүүдийн төлбөр төлсөн байдал зэрэгт үндэслэн найдваргүй авлагын хасагдуулга нь зохистой эсэхийг үнэлэх;
- 4- Тайлант хугацааны дараа цуглуулагдсан авлагыг холбогдох баримтуудтай тулгах;
- 4- Түүврийн аргаар өмнөх жилүүдэд удирдлагын тооцоолсон найдваргүй авлагын хасагдуулга нь зохистой байсан эсэхийг төлөгдсөн авлага, бодит найдваргүй авлагын зардлыг холбогдох анхан шатны баримтуудтай нь тулган баталгаажуулах.

в/ Татварын тооцооллын үнэн, зөв байдал

Татварын өр төлбөрийн тооцоололт болон татварын хууль тогтоомжийн хэрэгжүүлэлт нь үнэлэмж шаарддаг учраас бид татварын тооцооллын үнэн, зөв байдлыг аудитын гол асуудал гэж үзсэн.

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилттэй холбоотойгоор Монголын Засгийн Газар бизнес болон эдийн засгийн бүтцэд өөрчлөлт шинэчлэлтийг хийсээр байна. Үүний үр дүнд бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хууль журмууд ч мөн

өөрчлөгдсөөр байна.

Өөр өөр эрх бүхий байгууллагууд татварын хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж төлбөр торгууль тавих хуулиар тогтоосон эрхтэй байдаг. Компани татварын хууль тогтоомжийн ойлголт дээрээ үндэслэн бүх татваруудыг үнэн зөв тодорхойлсон гэж итгэж байгаа боловч дээр дурдсан хүчин зүйлүүдээс шалтгаалсан татварын эрсдэл байсаар байна.

Татварын тооцооллын үнэн зөв, зохистой байдлыг үнэлэхтэй холбоотой бидний гүйцэтгэсэн горимууд:

- ± Татварын тооцоолол ба түүнтэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлого болон татварын талаарх удирдлагын байр суурь, үнэлгээг судлах, ойлгох;
- \* Татварын хууль, журам дүрэм болон практик туршлагатай өөрсдийн татварын мэргэжилтнүүд болон Компани ба эрх бүхий татварын албадууд хоорондын харилцааг ашиглан санхүүгийн тайланд бүртгэгдсэн татварын өр төлбөрүүд нь зохистой эсэх, эсвэл татварын өр төлбөрийг бүртгээгүй үндэслэл шалтгааныг үнэлэх;
- 4- Санхүүгийн тайланд бүртгэгдсэн татварын өр төлбөр болон тодруулга нь хангалттай эсэх, уг өр төлбөр нь татварын хуулийн сүүлийн өөрчлөлтүүдийн дагуу тооцоологдсон эсэх, боломжит татварын торгууль болон хүүг агуулсан эсэхийг үнэлэх.

#### Бусад мэдээлэл

Энэхүү санхүүгийн тайланд өгөх манай дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид бусад мэдээлэлд ямар нэгэн дүгнэлт өгөхгүй. Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид дээр тодорхойлогдсон бусад мэдээллийг бэлэн болсон үед унших үүрэгтэй бөгөөд бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад цуглуулсан мэдээллээс материаллаг хэмжээний алдаатай эсэхийг авч үзэх ёстой.

Бусад мэдээллийгуншиж, бусад мэдээлэл нь материаллагхэмжээний зөрүүтэй эсвэл алдаатай байвал бид холбогдох эрх бүхий этгээдэд мэдэгдэх үүрэгтэй бөгөөд бид бусад горимыг гүйцэтгэж, дараах зүйлсийг тодорхойлно:

- 4- Бусад мэдээлэл нь материаллагхэмжээний алдаатай эсэх;
- 4- Санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай эсэх; эсвэл
- 5- Түүний орчны талаарх бидний ойлголтыг шинэчлэх хэрэгтэй эсэх.

Хэрэв бид бусад мэдээлэлд материаллаг хэмжээний алдаа байгаа гэж үзсэн ба түүнийг нь залруулаагүй бол, бид залруулагдаагүй материаллаг хэмжээний алдааг манай тайлангийн мэдээлэл хэрэглэгчдэд хүргэхийн тулд зохистой арга хэмжээ авахыг холбогдох эрх бүхий этгээдээс хүсэх болно.

Хэрэв бид аудитлагдсан санхүүгийн тайлан болон түүний орчны талаарх бидний ойлголтод материаллаг хэмжээний алдаа байна гэж үзвэл, бид АОУС-ын дагуу холбогдох арга хэмжээг авна.

## Санхүүгийн Тайлантай холбоотой Удирдлагын эрх Бүхий Этгээдийн Үүрэг

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэжтогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

## Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэгчлэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

## Бусад хууль эрх зүйн шаардлагуудын талаарх тайлан

Монгол улсын Компанийн тухай хуулийн 92 болон 94-р зүйлийн дагуу бид дараах тохиолдлуудад та бүхэнд тайлагнах үүрэгтэй:

- 4- Сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээ;
- < Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалттай холбоотой зөрчил;
- А Компанийн дүрмийн дагуу болон аудитын гэрээний дагуу шаардагдах бусад мэдээлэл

Дээрх зүйлстэй холбоотой ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

(7)

Я.Аюушжав

Захирал

Аяа Тах Аудит ХХК

ТАТД С55С6253 иТ

2025 оны 6 -рсарынлЧ

**СТАНДАРТ НООС ХК-ИЙ АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**  
**2024 ОНЫ 12САРЫН31**

Балансын зүйл	Тодруулга	Аяа Такс Аудит ХХК	
		2023	2024
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө Урьдчилж төлсөн зардал, тооцоо	1	801,615,667	1,186,737,443
Үндсэн хөрөнгө	2	30,524,800	30,524,800
<b>НИЙТХӨРӨНГӨ</b>		<b>832,140,467</b>	<b>1,217,262,24</b>
Дансны өглөг	3	801,615,667	1,186,737,443
Нийт өр төлбөрийн дүн		<b>801,615,667</b>	<b>1,186,737,44</b>
Өмч			
Хувьцаат	4	30,524,800	30,524,800
Хуримтлагдсан ашиг (алдагдал)			
Өмчийн нийт дүн		<b>30,524,800</b>	<b>30,524,80</b>
<b>ӨР ТӨЛБӨРБА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>		<b>832,140,467</b>	<b>1,217,262,24</b>
			3

**СТАНДАРТ НООС ХК-ИЙ АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ТАЙЛАН**  
**2024 ОНЫ 12САРЫН 31**

Такс Аудит ХХК Үзүүлэлт	Тодруулга	Аяа 2024
Борлуулалтын орлого (цэвэр) Нийт ашиг (алдагдал)		-
Борлуулалт, маркетингийн зардал Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		-
Орлогын татварын зардал Татварын дараах ашиг (алдагдал)		-
Тайлангийн үеийн цэвэр ашиг (алдагдал) Орлогын нийт дүн		-

**СТАНДАРТ НООС ХК-ИЙ АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН  
2024 ОНЫ 12 САРЫН 31**

<i>Үзүүлэлт</i>	<i>Өмч</i>	<i>нийт дүн</i>
<i>20... оны 1-р сарын 1-ний үлдэгдэл</i>	30,524,800	30,524,800
<i>Залруулсан үлдэгдэл</i>	30,524,800	30,524,800
<i>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</i>		-
<i>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</i>	30,524,800	30,524,800
<i>НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны</i>		
<i>залруулга</i>		
<i>Залруулсан үлдэгдэл</i>	30,524,800	30,524,800
<i>Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал</i>		-
<i>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</i>	30,524,800	30,524,800

*Аяа Такс Аудит  
ХХК*

**СТАНДАРТ НООС ХК-ИЙ АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
2024 ОНЫ 12 САРЫН 31**

<i>ҮЗҮҮЛЭЛТ</i>	<i>Аяа Такс Аудит ХХК 2024</i>
<i>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</i>	
<i>Мөнгөн орлогын дүн (+)</i>	
<i>Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого</i>	
<i>Мөнгөн зарлагын дүн (-)</i>	
<i>Ажиллагчдад төлсөн</i>	
<i>Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн</i>	
<i>Бусад мөнгөн зарлага</i>	
<i>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</i>	
<i>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</i>	
<i>Мөнгөн орлогын дүн (+)</i>	
<i>Үндсэн хөрөнгө борлуулсны орлого</i>	
<i>Мөнгөн зарлагын дүн (-)</i>	
<i>Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн</i>	
<i>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</i>	
<i>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</i>	
<i>Мөнгөн орлогын дүн (+)</i>	
<i>'Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан</i>	
<i>Мөнгөн зарлагын дүн (-)</i>	
<i>Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө</i>	
<i>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</i>	
<i>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</i>	
<i>Мөнгө, түүнтэй адитгах хөрөнгийн эхний үлдэгдэл</i>	
<i>Мөнгө, түүнтэй адитгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</i>	

*Аяа Такс ятН(Б)С,  
Улсын төрийн хувийн эзэмшсэн хувийн хэргийн хууль зөрчлөлийн  
Хяналтын байр*



## **1. Үндсэн үйл ажиллагаа ба зохион байгуулалт**

СТАНДАРТ НООС ХК нь 1996 оны 04 сарын 15-ны өдөр дотоодын хөрөнгө оруулалттай, 1331 гишүүнтэйгээр 30.410,5 сая төгрөгийн дүрмийн сантайгаар байгуулагдсан бөгөөд одоогийн байдлаар дүрмийн сан 30.524,8 сая төгрөг болж өөрчлөгдсөн байна.

Үйл ажиллагааны чиглэл: Тус компани худалдаа үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг.

Хаяг: Албан ёсны хаяг нь Монгол Улс, Баянхонгор аймаг, 1-р баг, Номгон

СТАНДАРТ НООС ХК-ийн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодотголууд 2024 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болгож санхүүгийн тайлангаа 2025 оны 2-р сарын 10-нд гаргасан.

## **2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй**

### **2.1 Мөрдсөн стандарт**

Санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын (СТОУС) дагуу бэлтгэж, тайлагнасан болно.

### **2.2 Санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь**

Санхүүгийн тайланг зарим үндсэн хөрөнгөөс бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт үндэслэн бэлтгэсэн. Нягтлан бодохбүртгэлийн бодлогод тусгаснаар зарим үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн үнэ буюу бодит үнэ цэнээр бүртгэсэн. Түүхэн өртөг нь хөрөнгийг худалдан авах үед төлсөн эсвэл солилцсон зүйлийн бодит үнэ цэнэ байдаг.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг үйл ажиллагааны үндсэн мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр илэрхийлсэн. Бүх санхүүгийн мэдээллийг өөрөөр заагаагүй бол төгрөгөөр илэрхийлсэн.

### **2.3 Бараа материал**

Бараа материалыг анх өртгөөр нь бүртгэдэг. Дараа нь бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар тайлагнадаг. Бараа материалын өртгийг сарын жигнэсэн дундаж өртгийн аргаар тооцоолдог. Цэвэр боломжит үнэ цэнэ гэдэг нь хэвийн бизнесийн нөхцөлд бараа материалын тооцоолсон худалдан борлуулах үнээс түүнийг үйлдвэрлэх болон худалдан борлуулахад нэмж гарахаар тооцсон зардлыг хассан дүн юм.

### **2.4 Үндсэн хөрөнгө**

Хайгуул үнэлгээний хөрөнгийг гарсан зардлаар тухай бүр нь бүртгэж ирсэн.

#### **Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийг анхны өртгөөр нь бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн өртөг дараах зардлуудаас бүрдэнэ. Үүнд:

- Хөнгөлөлт урамшууллын дараах худалдан авсан үнэ, гаалийн татвар болон худалдан авалттай холбоотой буцаан олгогдохгүй татвар
- Удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож түүнийг байршуулах болон шаардлагатай нөхцлийгхангахтай холбоотой гарсан аливаа шууд зардлууд

Худалдаж авсан программ хангамж нь холбогдох тоног төхөөрөмжийн үйл ажиллагаатай салшгүй холбоотой бол тухайн тоног төхөөрөмжийн нэг хэсэг байдлаар капиталжуулна.

Тайлант үеийн эцэст газар болон барилгаас бусад үндсэн хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнэ бууралтыг хассан дүнгээр хэмжсэн.

Үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан дараа үеийн зардал нь тухайн хөрөнгийн анх тооцсон бүтээмжийн түвшинг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн ирээдүйн өгөөжийг авчрах магадлалтай үед зардлын дүнгээр хөрөнгийн дансны үнийг нэмэгдүүлдэг.

Бусад бүх худалдан авалтын дараа гарсан зардлуудыг гарсан тайлант үед нь зардлаар бүртгэнэ. Газар болон дуусаагүй барилгаас бусад үндсэн хөрөнгийн өртөг эсвэл дахин үнэлсэн дүнгээс тэдгээрийн үлдэгдэл өртгийг хассан дүнг шулуун шугамын аргаар, ашиглалтын жилд нь элэгдүүлдэг. Тооцоолсон ашиглалтын жил, үлдэх өртөг болон элэгдлийг бодох аргыг тайлан

гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил:

Газар	Элэгдэл байгуулдаггүй
Барилга байгууламж	10-40 жил
Тоногтөхөөрөмж	10 жил
Тавилга, эд хогшил, компьютер	3-10 жил
Тээврийн хэрэгсэл	10 жил

Үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн

хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар

ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл үндсэн хөрөнгийн зүйлийг бүртгэлээс хасдаг.

Үндсэн хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг алдагдалд тусгана.

## 2.5 Биет бус хөрөнгө

Ашиглагдах жил нь тодорхой, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдэл ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжсэн. Биет бус хөрөнгийн хорогдлыг шулуун шугамын аргаар, биет бус хөрөнгийн ашиглалтын жилээр тооцоолсон. Тооцоолсон ашиглалтын жил болон элэгдэл бодох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг. Ашиглагдах жил нь тодорхойгүй, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өртгөөс нь үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжсэн. Биет бус хөрөнгийн ашиглалтын жил нь 3-5 жил. Биет бус хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл хөрөнгийн зүйлийг бүртгэлээс хасдаг. Биет бус хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг алдагдалд тусгана.

## 2.6 Биет ба биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант үеийн эцэст биет хөрөнгийн дансны үнийг үнэ цэнэ бууралтын шинж тэмдэг илэрсэн эсэхийг тодорхойлох шалгалтанд хамруулдаг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрсэн бол үнэ цэнэ бууралтын алдагдал (ийм алдагдал гарсан бол)-ыг тогтоохын тулд тухайн хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлно.

## 2.7 Санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хөрөнгө нь зээл ба авлагаас бүрдэж байна.

### 2.7.1 Зээл ба авлага

Дансны авлага гэх мэт зарим санхүүгийн хөрөнгө нь дангаараа үнэ цэнийн бууралтанд өртөөгүй гэж үзсэн ч нийт багцын хувьд үнэ цэнийн бууралт явагдсан эсэхийг шалгана. Авлагаа цуглуулдаг туршлага, 30 хоногийн дундаж зээлийн хоногоос хугацаа хэтэрсэн авлагын тоо нийт авлагын багцад өссөн, мөн авлага төлөгдөхгүй, төлбөрийн чадваргүй болж байгаа нь улсын болон орон нутгийн эдийн засгийн нөхцөл байдал мэдэгдэхүйц өөрчлөлттэй холбоотой байвал авлагын багцын үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо гэж үздэг. Авлагаас бусад санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг тухайн хөрөнгийн дансны үнийг бууруулж бүртгэнэ. Худалдааны авлагын хувьд найдваргүй авлагын сангийн дансаар дамжуулж үнэ цэнэ бууралтын алдагдлыг бүртгэдэг. Авлагыг цуглуулах найдваргүй гэж үзвэл авлагыг найдваргүй авлагын сан руу хааж данснаас хасдаг. Данснаас хассан авлага дараа нь төлөгдвөл найдваргүй авлагын санд бичсэн бичилтийг буцаана. Найдваргүй авлагын сангийн дансны үлдэгдлийн өөрчлөлтийг ашиг алдагдалд тусгана.

## 2.8 Санхүүгийн өрийн ба өмчийн хэрэгсэл

Компанийн гаргажбайгаа өрийн болон өмчийн хэрэгслийг тэдгээрийн гэрээнд тусгагдсанаар ямар нөхцөл, бодит байдал үүссэн бөгөөд санхүүгийн өр эсвэл өмчийн хэрэгслийн тодорхойлолтод

нийцэж байгаа эсэхийг үндэслэн өр эсвэл өмчийн хэрэгсэл гэж ангилдаг.

#### 2.8.1 Өмчийн хэрэгсэл

Хөрөнгөөс өр төлбөрийг хассаны дараа үлдэх хэсгээс хувь хүртэх нөхцөл бүхий аливаа гэрээг өмчийн хэрэгсэл гэдэг. Компани гаргаж байгаа өмчийн хэрэгслийг хүлээн авсан мөнгөнөөс санхүүгийн хэрэгслийг гаргахтай холбоотой шууд зардлыг хассан дүнгээр хэмжиж бүртгэдэг. Компани өөрийн гаргасан өмчийн хэрэгслийг буцаан худалдан авбал өмчийн хэсгийг бууруулж бүртгэдэг. Өөрийн өмчийн хэрэгслийг худалдан авах, худалдах, гаргах, хүчингүй болгохтой холбоотойгоор ашиг алдагдлын тайланд олз гарз бүртгэхгүй.

#### 2.8.2 Санхүүгийн өр төлбөр

Гэрээний нэг оролцогч тал болсон үед санхүүгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгадаг. Санхүүгийн өр төлбөрийг анх үүсэх үеийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг өрийн хэрэгслээс бусад санхүүгийн өр төлбөрийг гаргахтай холбоотой гарсан ажил гүйлгээний өртгийг тухайн өр төлбөрийн анхны өртөгт оруулж бүртгэдэг.

Санхүүгийн өр төлбөрийг "бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг" өрийн хэрэгсэл эсвэл бусад санхүүгийн өр төлбөр гэж хоёр ангилдаг. Санхүүгийн өр төлбөр нь зөвхөн бусад санхүүгийн өр төлбөрөөс бүрдэнэ.

### 2.9 Орлого хүлээн зөвшөөрөлт

Орлогыг харилцагчаас хүлээн авсан болон хүлээн авах зүйлийн бодит үнэ цэнээр хэмждэг. Орлогыг тооцоолж буй борлуулалтын буцаалт, борлуулалтын хөнгөлөлт, эдгээртэй ижил төстэй хөнгөлөлтүүдийг хассан цэвэр дүнгээр бүртгэдэг.

#### 2.9.1 Борлуулсан бараа, бүтээгдэхүүн

Хэвийн бизнесийн нөхцөлд бараа, бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг борлуулалтын буцаалт, худалдааны хөнгөлөлтийг хассаны дараах хүлээн авсан эсвэл хүлээн авах авлагын бодит үнэ цэнээр хэмжинэ. Дараах бүх нөхцөл бүрдсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Барааг эзэмших, өмчлөхтэй холбоотой эрсдэл ба өгөөж нь худалдан авагчид шилжсэн;
- Борлуулсан барааныхаа өмчлөлд холбогдох удирдлагын болон хяналтын үүргийг өөртөө хадгалаагүй;
- Орлогыг найдвартайгаар хэмжих боломжтой;
- Ажил гүйлгээний эдийн засгийн өгөөжийг компани хүртэх магадлалтай;
- Тухайн ажил гүйлгээтэй холбоотой гарсан болон гарах зардлуудыг найдвартайгаар хэмжиж, тодорхойлох боломжтой; Ялангуяа, барааг худалдан авагчид хүргэсэн мөн хууль ёсны өмчлөл нь худалдан авагчид шилжсэн үед бараа, бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрдөг. Хэрэв хөнгөлөлт үзүүлэх нь магадлалтай, мөн дүнг нь найдвартайгаар хэмжих боломжтой бол орлогыг хүлээн зөвшөөрөхдөө уг хөнгөлөлтийг орлогоос хасч бүртгэнэ.

#### 2.9.2 Хүүгийн орлого

Эдийн засгийн өгөөж гэдэг зөвхөн банкны байгууллагаас харилцах дансны үлдэгдэлд тооцсон орлого найдвартайгаар компанид орсон тохиолдолд хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрнө.

### 2.10 Зардал хүлээн зөвшөөрөлт

Зардлыг иж бүрэн орлогын тайланд зардлын чиг үүргийн аргыг ашиглан тайлагнадаг. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт борлуулсан барааны бүтээгдэхүүнтэй шууд холбоотой зардлууд багтдаг. Харин үйл ажиллагааны зардалд ерөнхий ба удирдлагын, борлуулалт, маркетингийн болон бусад бизнесийн үйл ажиллагааны зардлууд ордог.

### 2.11 Татвар

Орлогын татварын зардал нь тухайн жилд төлөхөөр тооцсон татвараас бүрдэнэ.

#### 2.11.1 Тухайн жилийн орлогын албан татвар

Тухайн жилийн татварын өглөг нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод суурилсан байна. Татвар ногдуулах орлого нь санхүүгийн тайлангаар тодорхойлсон ашгаас зөрүүтэй байдаг нь санхүүгийн тайланд тусгагдсан орлого, зарлагын зүйлсийн татвар ногдох, татвар ногдох орлогоос

хасагдах хугацаа нь татварын тайлангийн зорилгоор өөр тайлант хугацаанд үүсдэг эсвэл эдгээр нь огт татвар ногдохгүй эсвэл татвар ногдох орлогоос хасагдахгүй байдагтай холбоотой. Тухайн жилийн татварын өрийг тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээгээр тооцож, тодорхойлно.

### **3. Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж ба тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж**

#### **3.1 Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж**

Монгол улсын татварын систем

Хэвийн бизнесийн үйл ажиллагааны явцад компани нь хууль, эрх зүйн асуудлууд, гомдол нэхэмжлэлд өртөж болно. Ийм хууль, эрх зүйн асуудал, гомдол нэхэмжлэл байгаа бол түүнээс гарах үүрэг хариуцлага нь ирээдүйн үйл ажиллагааны үр дүн болон санхүүгийн байдалд их хэмжээний сөрөг үр дагаврыг бий болгохгүй гэж удирдлага итгэж байна.

#### **3.2 Тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж**

Дараах санхүүгийн тайлангийн их хэмжээний дүн бүхий үзүүлэлтүүдэд дараах таамаглал төсөөллийг ашиглан, санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн.

Бараа материалын үнэлгээ

Компаний удирдлага удаан гүйлгээтэй, зарагддаггүй болон эвдэрч гэмтсэн бараа материалыг тодорхой хугацаагаар хянадаг ба үнэлэмж болон тооцооллыг ашигладаг. Эдгээр тооцооллоос хамаарч бараа материалын үнэлгээ өөрчлөгдөх боломжтой.

Компани нь бараа материалын үнэлгээг тооцохдоо бараа материалын насжилт дээр үндэслэн өмнөхжилүүдийн туршлага, түүхэн мэдээлэлд үндэслэн тооцсон хувиар тооцдог.

Удирдлага дээрх бараа материалын үнэлгээг тодорхойлоход хэрэглэсэн төсөөлөл болон үнэлэмж зохистой буюу тохиромжтой гэдэгт итгэж байна.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил

Компанийн үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн тооцооллыг санхүүгийн тайлангийн өдрөөр хянадаг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай бол залруулдаг. Тайлант жилийн эцэст үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн тооцоололд өөрчлөлт гараагүй.

### **Шинэ болон шинэчлэгдсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (СТОУС)**

#### **Тайлант жилд хэрэгжиж эхэлсэн шинэчлэгдсэн СТОУС болон шинэ тайлбарууд**

Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан 2018 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн СТОУС-ын өөрчлөлтүүдийг тайлант жилд хэрэгжүүлсэн.

Хэрэгжиж эхэлсэн  
хугацаа

Шинэчлэгдсэн СТОУС болон өөрчлөлтүүд

НББОУС 16 болон НББОУС 41-д хийгдсэн нэмэлт өөрчлөлт- Хөдөө Аж Ахуй

СТОУС 11-д хийгдсэн нэмэлт өөрчлөлт- *Хамтарсан үйл ажиллагааны хувь оролцоог олж эзэмших үеийн нягтлан бодох бүртгэл*

НББОУС 16 болон НББОУС 38-д хийгдсэн нэмэлт өөрчлөлт- *Элэгдэл ба*

2018 оны 1 сарын 1 *хорогдлын зохистой аргачлалын ангилал*

НББОУС 1-д хийгдсэн нэмэлт өөрчлөлт - *Санхүүгийн тайлангийн толилуулга*

НББОУС 27- д хийгдсэн нэмэлт өөрчлөлт -*Тусдаа санхүүгийн тайлан дахь өмчийн арга*

СТОУС 10, СТОУС 12 ба НББОУС 28-д хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүд  
*Хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгж: тайлан бэлтгэхээс чөлөөлсөн нөхцлүүд*

СТОУС-ын 2012-оос 2014 оны мөчлөгт хийгдсэн *Жилийн шинэчлэлүүд*

Дээрх стардартын өөрчлөлт болон тайлбарууд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад нөлөөлөх хэмжээний өөрчлөлтүүдийг бий болгоогүй бөгөөд санхүүгийн тайланд нөлөөлөөгүй болно.

### **Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй стандартууд**

Санхүүгийн тайлангуудыг батлан гаргах үед батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд болон тайлбаруудыг доор тодруулсан болно. Эдгээр стандартууд болон өөрчлөлтүүд нь санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхээр бол Групп эдгээрийг хэрэгжиж эхэлсэн үеэ дагаж мөрдөнө.

*Хэрэгжих хугацаа*

*Шинэ стандартууд болон өөрчлөлтүүд*

*2017 оны 1сарын 1 НББОУС 7-д хийгдсэн өөрчлөлт - Тодруулга*

*СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл*

*СТОУС 15 Худалдан авагчтай байгуулсан гэрээнээс орох орлого*

*СТОУС 2-д хийгдсэн өөрчлөлт - Хувьцаанд суурилсан төлбөрийн*

*Хэмжилт болон Ангилал*

*2018 оны 1сарын 1 СТОУТХ 22 Гадаад валютын гүйлгээ ба урьдчилгаа*

*НББОУС 40-д хийгдсэн өөрчлөлт - Хөрөнгө оруулалтын зориулалттай*

*үл хөдлөх хөрөнгийн шилжүүлэлт*

*СТОУС 15-д хийгдсэн тайлбар Худалдан авагчтай байгуулсан*

*гэрээнээс орох орлого*

### **1. Урьдчилж төлсөн зардал/тооцоо**

	2023	2024
	801,615,667	1,186,737,443
Дүн	801,615,667	1,186,737,443

### **2. Хөрөнгө**

	2023	2024
Хөрөнгө	30,524,800	30,524,800
Дүн	30,524,800	30,524,800

### **3. Дансны өглөг**

	2023	2024
Төлөгдөх хугацаандаа байгаа	801,615,667	1,186,737,443
Дүн	801,615,667	1,186,737,443

### **4. Эзний өмч**

	2023	2024
Энгийн хувьцаа	30,524,800	30,524,800
Дүн	30,524,800	30,524,800